

Конечно, я не могу отрицать, что в этом году мы провели много интересных мероприятий, но я бы хотел, чтобы в следующем году мы организовали больше мероприятий, направленных на поддержку молодежи и ее творчества. Для этого нам нужно будет найти спонсоров, которые помогут нам организовать такие мероприятия. Я надеюсь, что в следующем году мы сможем провести более масштабные и интересные мероприятия, направленные на поддержку молодежи и ее творчества.

## ЭДИЙН ЗАСГИЙН СУУРЬ САЛБАРЫН НӨӨЦИЙН ХӨГЖИЛ

К.Аксолтан

МАА манай эдийн засгийн уламжлалт суурь салбар. МАА эрт дээр үеэс тус орны эдийн засгийн үндэс байсан, одоо ч нөлөө нь алдагдаагүй явна. Улс орны эдийн засагт энэ салбарын гүйцэтгэж байгаа одоогийн бодит үүрэг, ач холбогдол доорхи тоо баримтаас тодорхой харагдаж байна. Үүнд: 2000 оны байдлаар ажиллагсадын 48.6 хувийг ХАА (гол нь МАА) эзэлж байна. Зах зээлийн одоогийн нөхцөлд малчид хүнсний болон хүнсний биш бараг бүх хэрэглээгээ энэ салбарын бүтээгдэхүүн, түүхий эдийн худалдаанаас авч хангаж байгаа. Хэрэв боловсруулах үйлдвэрийн ноолууран бүтээгдэхүүнийг оруулж тооцвол нийт экспортын бараг 56 хувь нь (2000 онд) МАА-гаас хамааралтай гэж үзэж болно.

33ЭЗ-ийн үед аливаа салбарын байр суурийг ДНБ-ээр хэмждэг. Тэгвэл энэхүү бүтээгдэхүүний 1995 онд 41.1, 2000 онд 32.0 хувь нь зөвхөн (оны үнээр, урьдчилсан тооцоо) МАА-д бий болсон. Яг одоо Монголын экспорттын 3 гол тулгуур нөөцийн хоёр нь (ямааны ноолуур, тэмээний ноос) МАА-н салбарт байна. МАА-н негеө нэг ач холбогдлыг нүүдлийн соёл иргэншилтэй холбож үзэх хэрэгтэй. Бэлчээрийн нүүдлийн МАА байгаа учраас одоогийн Монгол орчин ахуй, соёл, ёс заншил, өвөрмөц амьдрал, байгаль экологийн цэвэр, ариун орчин хадгалагдаж иржээ гэж эрдэмтэд дүгнэж байна. Энэ бүхэн нэг талаас, тус орон дахь МАА-н хэмжээ, далайцыг харуулж байгаа бол негеө талаас, энэ их нөөцийг үр ашигтай, зүй зохистой ашиглах арга замыг зөв сонгож олох асуудлыг биднээс шаардаж байна.

Монгол бол малын нээц баялаг ихтэй орон. Малын тоо 1999 онд 33.6 сая болтол

өссөн боловч сүүлийн жилүүдэд тохиолдсон байгалийн ган, зудаас болж 2002 онд 23.6 сая болтол буураад байна. Нэг хүнд ногдох малын тоогоор дэлхийд Австрали, Шинэ Зеландийн дараа гуравдугаарт ордог.

2.4 сая хүнд 24 сая мал байна гэдэг тооны хувьд чамалхааргүй овоо хөрөнгө юм шиг санагдавч манай хоёр үхрээс авах махыг нэг үхрээс, долоон үнээнээс авах сүүг нэг үнээнээс саадаг өндөр ашиг шимтэй дэлхийн МАА-н түвшинтэй харьцуулахад тийм ч гайхуулахаар их баялаг (мал) биш юм. Энэ нь түүний өргтийн үнэлгээний талаас ч тодорхой харагддаг. Тус улсын нийт малын үнийг одоогийн зах зээлийн ханшаар тооцож үзвэл 800 гаруй тэрбум төгрөг буюу ойролцоогоор 727 сая амдоллартай (800 тэрб₮:1100₮=727.3 сая) тэнцэх төдий л хөрөнгө болно. Харин энэхүү хөрөнгийн яндашгүй нэг давуу тал бол биологийн жам ёсоор жил бүр байнга өсөн үржиж, нөхөн сэргээгдэж байдагт оршино. Өөрөөр хэлбэл, ертөнцийн мөнхийн үйлдвэрлэл гэж хэлж болно. Малын нөөц нь байгаль, биологийн талаас зохих хязгаартай, шинжлэх ухааны ирээдүйн ололтын талаас тэрхүү хязгаарыг харьцангуй гэж хэлж болно.

### 1. Малын тоо толгойн нөөц

Малын тоо толгойн өсөлтийн талаар ярихад бэлчээрийн асуудал зайлшгүй хөндөгддөг. Яагаад гэвэл манай мал сүрэг өвс тэжээлийнхээ бараг 99 хувийг бэлчээрээс олж иддэг. Бэлчээрийн даацын талаар янз бүрийн тооцоо судалгааг ярьдаг боловч дунджаар 60 сая хонь багтах тэжээлийн нөөцтэй гэж албан ёсоор үзэцгээдэг юм. Миний (К.Аксолтан) хувьд зохих тооцоо, судалгааг үндэслэн манай бэлчээрийн дээд нөөцийг, бүрэн усжуулж ашигласан нөхцөлд 90 сая хонь багтах даацтай гэж үздэг. Мэдээж байгаль, цаг уурын хэвийн нөхцөлд шүү дээ. Сүүлийн үед зарим, мэргэжлийн гол эрдэмтэд (доктор, профессор С.Цэрэндаш 2002 он) "... 86 гаруй сая хонь толгой барих экологийн нөөц бий" гэж тодорхойлсноор үндсэндээ бид санал нэгдэж байх шиг байна. Бэлчээрийн дээрх даац нь таван хошуу малын одоогийн биет бүтцээр 40 гаруй сая малд хүрэлцэхээс 1999 онд 33.6 сая буюу 84 хувьд нь хүрээд авсан гэж хэлж болно. Өнөөдөр малын тоо 23.6 сая болтол багасч хорогчихсон нь дээрх хийсэн тооцооны үндэслэлтэй огт холбоогүй, харин дэлхийн түүний дотор Монголын байгаль, цаг уурт гарч байгаа зохисгүй эрс өөрчлөлтийн хор уршиг, үр дагавраас болж байгаа зүйл.

Сүүлийн үед бэлчээрийн даац хэтэрсэн, Монгол нутагт мал ёсгех бололцоогүй болсон мэтээр ярьж, сурталдах болж. Би ийм үндэслэлтэй санал нийлдэггүй. Ганцхан жишээ хэлэхэд, одоо хэр усжууллагаагүйгээс юмуу эсвэл төв суурин, зам харгуйгаас хэт алслагдсанаас нийт бэлчээрийн 40-50 хувь нь ашиглагдахгүй байхад бэлчээр мал багтахаа байлаа гэдэг үндэслэл бодит байдалтай нийцэхгүй байна. Малчид зах зээлд ойртохын тулд урьдын бэлчээр нутгаа орхиж, хот суурин газар бараадаж бөөгнөрснөөс тодорхой нутагт (Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Сэлэнгэ) бэлчээр талхлагдаж хүрэлцэхгүй болж байгаа явдал бий. Энэ бол бэлчээрийн гэхээсээ зах зээлийн үеийн бодлого, зохицуулалт, зохион байгуулалт, арга механизмын дутагдалтай холбоотой асуудал. Хэрэв заавал хот орчимд МАА эрхлэхийг сонирхож байгаа бол малыг бэлчээрийн биш эрчимтэй байран (хагас байран) аргаар эрхлэх ёстой. Хотоо тойруулж бэлчээрийн МАА эрхэлж зах зээл хөгжүүлдэг орон гэж хaa ч

байхгүй. Дүгнэж хэлэхэд, Монголчууд өвс бэлчээртэй газраа хүрч, бүрэн усжуулж ашиглаж чадахгүй байгаа болохоос биш, бэлчээр нь дутагдсанаас бүхэлдээ мал ёсгех боломжгүй болчихсон юм байхгүй.

Өвс тэжээлийн ургац байгаль, цаг агаарын аясаар байнга хэлбэлзэж байдаг нь үнэн боловч, үүнээс хойш манай нутагт дандаа ган болж өвс ногоо ургахгүй гэсэн баталгаа хaa ч байхгүй. Хэрээс хэтэрсэн хуурайшилт болох юм бол бэлчээрийн байтугай байран МАА ч тэжээлгүйдэж сүйрдэг юм. Ийм болохоор байгалийн хүчээр (ган, зудаар) хэт далайлгах хэрэггүй.

Харин түүний оронд газар дэлхийн бэлэн буян хишгээр, (өвс, усаар) ганц ч мөнгөний гарлагагүйгээр малаа тэжээж услачихаад залхуурч хэвтдэг нүүдэлчин сэтгэхүйгээсээ салах хэрэгтэй. Нүүдэлчид байгалийн бэрхшээлийг сэргэж ажиллахын оронд түүнээс зутаж зайлхыг эрхэм болгодог нь тэдний гол зарчим байсан, одоо ч байна. ХХI зуун гарчихаад байхад манай малчдын үндсэн хэв шинж нь яг хуучин нүүдэлчин хэвээрээ. Гэтэл бид чинь одоо нэг талаас, зах зээлийн тогтолцоот нийгэмд шилжиж байна. Нөгөө талаас, байгалийн болзошгүй аюулын (ган, зудын) давтагдах хугацаа богиносч, учруулах хор уршгийн хэмжээ улам ёсч байгаа учраас тодорхой хэмжээний хөдөлмөр, хөрөнгө хүч зарж байж тэрхүү бэрхшээлээс мал сүрэг, эд хөрөнгөө хамгаалах хэрэгтэй гэдгийг ойлгох цаг нэгэнт болсон.

### 2. Малын үүлдэр угсаа, ашиг шимиийн нөөц

Үүлдэр угсаа, ашиг шим нь МАА-н эрчимжилтийн түвшнийг харуулдаг гол үзүүлэлт. Монгол нутагт таван хошуу малын 32 үүлдэр, омог, хэвшил байгаагаас тэмээ, адуу, үхрийн тус бүр 4, хонинах 15, ямааных 5 байна. Гэвч нэгжийн ашиг шимиийн гарцаар Монгол мал (нутгийн үүлдрийн) дэлхийн түвшинтэй харьцуулахад үнэхээр ядмагт тооцогддог. 1991 оны байдлаар манай нутгийн үхэр, гулууз махны жингээр дэлхийн дунджаас 58.3 хувь, үнээнээс саасан сүүгээр 7.8 дахин, нэг хониноос авсан ноосоор 75 хувиар бага байсан. Хэдий ийм боловч Монгол малд цаашид дэлхийн зах зээлд бүтээгдэхүүнээрээ өрсөлдөх өөр давуу чанарууд бий. Үүнд: **Нэгд**, маханд нь янз бүрийн амин хүчил, амин дэм (B-12), зэс, төмөр зэрэг микро элемент ихтэй, шингэц сайтай экологийн цэвэр бүтээгдэхүүн юм. **Хоёрт**, Монгол ямаа өөрийн ноолуурын чанараараа дэлхийд хосгүй генефонд, онцгой ашиг шимтэй мал. Энүүгээр манайхтай Хятадаас өөр өрсөлдөх орон байхгүй. **Гуравт**, нутгийн үүлдрийн шилмэл омгийн малын тоог ёсгеж олон болговол хэтдээ байгалийн бэлчээрийн нөхцөлд ч бүтээгдэхүүнийхээ нөөцийг нэмэгдүүлэх ихээхэн бололцоо бий. Шилмэл малын ашиг шим ердийн малынхаас 15-30 хувиар илүү байдаг. Ганцхан жишээ хэлэхэд ямааныхаа чанарыг сайжруулж ноолуурын гарцыг 20 хувь нэмэгдүүлэхэд л 2000 оны үйлдвэрлэлийн хэмжээг 660 тонноор ёсгех бололцоотой гэсэн үг. 2000 онд бүгд 791.0 мянган шилмэл омгийн мал байсны (бүх малын 2.6 хувь) 59.2 хувийг хонь, 35.7 хувийг ямаа, 4.2 хувийг адуу эзэлж байв. Бид эрчимжүүлэлттэй дүйцэхүйц энэ чухал нөөц боломжийг дайчилж ашиглах талаар үнэхээр бага ажиллах байгаа нь нийт сүрэгт энэ хэвшлийн малын эзэлж буй хувийн жингээс тодорхой харагдаж байна. Монгол мал нэгжийн ашиг шимиийн гарцаар эрчимжсэн МАА-тай өрсөлдөх боломжгүй. Тэгсэн атал өндөр ашиг шимтэй мал сүргээ ёсгех талаар бас л санаа тавьж байгаа

юм алга. 2000 онд үхэр, хонь ямаа нийлсэн цэвэр үүлдрийн 731.5, эрлийз 1109.3 мянг: мал байгаа нь бүх малын дөнгөж 6.1 хувьтай тэнцэж байна. Энэ бол үнэхээр чамлахаар бага тоо. Цаашид өндөр ашиг шимтэй малын тоог эрчимтэй ёсгэж МАА-н бүтээгдэхүүний нөөцөд тэргүүлэх байртай болгох хэрэгтэй. Манайхан угийн нүүдэлчин сэтгэхүйгээрээ байгалийн бэлэн үр өгөөжид дулдуйдсан эрчимгүй аж ахуйн аргад хэт найдаад ХАА-г эрчимжүүлэхийн ач холбогдлыг төдий л үнэлж үздэггүй, цаг ямагт хоёрдугаарт тавьж ирсэн. Харин сүүлийн хэдэн жилийн ган, зуднаас л хүмүүс сая л нэг яс, махандaa тултал ойлгох шиг боллоо.

### 3. Мал аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эдийн нөөц

Бүтээгдэхүүн нь зөвхөн МАА ч биш аливаа үйлдвэрлэлийн есөлтийн гол үзүүлэлт. МАА-н бүтээгдэхүүн, түүхий эдийн нөөцөд мах, сүү, ноос, ноолуур, хөөвөр, хялгас, арьс шир, өлөн гэдэс, бусад дайвар зүйлс орно. Эдгээр бүтээгдэхүүн, түүхий эдийн нөөц нь нэг талаас, малын тоо, ашиг шимиийн гарцтай, нөгөө талаас, тухайн улс орны хэрэглээ, экспортын есөлттэй холбоотой.

МАА-гаас зөвхөн ганцхан жилд гэхэд л (2000 онд) 310.6 мян.тонн мах, 375.6 мян.тонн сүү, 21.7 мян.тонн хонины ноос, 3.3 мян.тонн ноолуур, 1411.6 мян.ширхэг бодын шир, 6707.7 мян.ширхэг бодын арьс, мөн төдий хэр гогцоо өлөн гэдэс гарч байдаг. Хэдийгээр чанар нь доогуур ч гэсэн эдгээр түүхий эдийг ашиглан манай боловсруулах үйлдвэрүүд 1989 онд 2962 тонн ээrsэн утас, 248.6 мянган ширхэг сүлжмэл эдлэл, 128 мян.кв.метр хивс, 529 мянган хос эсгий гутал, 1990 онд 1929.0 мян.кв.метр шеврет, шевро, 1000 тонн улны шир, 300.0 мян. ширхэг төрөл бүрийн савхин хувцас, 180.0 мянган нэхий дээл үйлдвэрлэж, түүнээс бас экспортлож байсан юм. Ийнхүү хөнгөн аж үйлдвэр улс орны эдийн засагт тэргүүлэх байрыг эзэлж, үндэсний орлого, гадаад худалдаанд эзлэх хувь хэмжээгээрээ уул уурхайн салбараас ч хоёр дахин илүү жин дарж байсан удаатай. Гэтэл одоогоос 13 жилийн өмнө нийгмийн нийт бүтээгдэхүүнд дангаараа 20 шахам хувийг эзэлж байсан хөнгөн, хүнсний аж үйлдвэр өнөөдөр (1999 оньшоор) ДНБ-ний дөнгөж 5.7 хувийг эзэлдэг гэсэн тооцоо гарчээ. Үүнээс нэг үе улс орны эдийн засагт тэргүүлэх үүрэг нелөөтэй байсан салбар маань өнөөдөр зах зээлийн нехцөлд бараг байхгүйтэй (ноолуурын үйлдвэрлэлийг эс тооцвол) адил болжээ гэсэн дүгнэлт хийхэд хүргэж байна. Мөн сүүлийн арав гаруй жилд МАА-н түүхий эд түүхийгээрээ хямдхан хил гарч, үйлдвэрүүд сүл зогссон тооцоо ажилчид нь үгүйрэн хоосорч, үндэсний баялаг дундарч, улс орны хөгжил олигтой ахижгүй удаашираар байгаа нь мөнхүү боловсруулах үйлдвэрийн орон зай одоо хүртэл нөхөгдөөгүй хоосон байгаагийн шууд нелөөлөл гэж үзэж байна.

Зах зээлийн дундаж ханшаар нэг тэрбум ам.доллар хүрэхгүй үнэтэй мал сүрэг маань жилд 300 сая гаруй ам.долларын (2000 онд) нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Хэрэв түүхий эдийг хагас боловсруулбал үр дүн нь 3 дахин, бүтэн боловсруулбал 6 дахин өсдөг зүй тогтлыг үндэс болговол боловсруулах үйлдвэрээр дамжуулсан МАА-н бүтээгдэхүүний эцсийн үр дүн хичнээн их өсч арвиждаг нь тодорхой байна. Ийм учраас МАА байсан газар орчин үеийн боловсруулах үйлдвэрийг зайлшгүй хөгжүүлэх, энэ хоёр салбарыг хамтад нь цогцолбороор авч үзэх нь хөгжлийн зорилгод нийцнэ гэж үзэж байна.

Дээр дурдснаас гадна бидэнд бүрэн гүйцэд ашиглаагүй байгаа өөр олон төрлийн нөөцүүд бий. Үүнээс хамгийн том нөөцийн алдагдал нь мах, сүү, төлийн хорогдол дээр илэрдэг. Баримжаа тооцоогоор өнөөдөр сүүн бүтээгдэхүүнийхээ (үнээний) бололцоот нөөцийн 60-70 хувийг л (хонь, ямааны хувьд бүр ч бага) ашиглаж байна. Бүх хээлтэг малын 15-30 хувиас ямар нэг шалтгаанаар төл авч чаддаггүй. Үүнээс болж жил тутам ойролцоогоор 2-4 сая хүртэл төл алдаж байдаг.

Малын тураг махнаас нь гадна 30 гаруй төрлийн дайвар бүтээгдэхүүн (нойр булчирхай, хар гэдэс, дэлүү, сэвс, эвэр, туурай г.м) гардгийг мэргэжилтнүүд тодорхойлсон билээ. Байгалийн гаралтай зүйлийн хэрэглээг илүүд үздэг болж байгаа одоо үед дээрх бүтээгдэхүүнүүдийг зах зээл дээр их өндөр үнэлж авдаг нь зүйн хэрэг. Үхрийн нэг кг мах 1.5 гаруй ам.доллар байхад хонины гогцоо өлөн гурав, адууны хар гэдэс нэг ширхэг нь хоёр ам.доллар, үхрийн давсаг 60 цент байдаг гээд жил тутам хүнсэнд хэрэглэдэг 8 сая малаараа тооцоолоод үзэхэд ямар их үнэт баялаг ашиглагдахгүй хог болон үлдэж байна вэ. Ганцхан зүйлийг жишээ болгон хэлэхэд манай улс 2000 онд 886.6 мянган үхрийг хүнсэнд хэрэглэжээ. Хэрэв эдгээр малын давсгийг дээрх үнээр үнэлж экспортолсон гэж үзвэл 532 мянган ам.доллар буюу өнөөдрийн ханшаар 601 сая төгрөг болох ажээ. Энэ нь бид хэдийгээр МАА-н орон боловч одоо хүртэл малынхаа нөөцийг бүрэн гүйцэд ашиглаж, үнэлж, бас бусдад худалдаж сураагүй гэдгийг харуулж байна.

Дараагийн нэг том нөөцийн алдагдал бол малын өвөл, хаврын тарга, хучний алдагдлаас гарч байгаа юм. Байгаль, цаг уурын хатуу ширүүн нелөөнөөс болж нийт малынхаа тарга хүчнээс жилд ойролцоогоор 630-660.0 мян.тонн махны нөөц (малын тоо, бүтцээс хамаарч хэлбэлзэлтэй байдаг) алддаг гэсэн тооцоо гардаг. Ер нь байгалийн хараат байдлаас ангижраагүй цагт манай МАА, хүн амыг хүнсээр хангах асуудал өндөр эрсдэлийн дор оршиж байна. Тухайлбал. 1999 онд 33.6 саяд хүрсэн мал маань 2002 онд 10 саяар буюу даруй 30 хувиар хорогдоо.

Мэргэжлийн байгууллага, эрдэмтдийн үзэж байгаагаар Монгол улсын хүн ам 2020-ийд оны үед 3.5-4.2 сая болж 149-178 хувиар өснө гэсэн прогнози бий. Энэ үнэн бол цаашид мах, сүү зэрэг хүнсний нөөц хүн амын өсөлтөөс илт хоцрох төлөвтэй. Дэлхийн цаг уурт гарч буй дулааралтын нелөөлөлтэй холбож үзсэн ч цаашид мах, сүүний өсөлтийн хэрэгцээг малын тоо толгойн экстенсив өсөлтөөр хангах боломж нэн хязгаарлагдмал байх болно. Манай махны экспортын жилийн болоцоот дээд нөөцийг 50-60.0 мян. тонн гэж үздэг. Хэрэв үүнийг хожим өсөх хүн амынхаа хэрэглээнд зориулах юмаа гэж үзвэл ийм нөөцөөр нийт хүн амын хүнсний (макхны) 2012 оны, их сайндаа 2015 оны хэрэглээг хангахад л хүрэлцэх боломжтой. Товчоор хэлбэл, бэлчээрийн аргын хажуугаар МАА-г эрчимжүүлж ашиг шимиийг нь нэмэгдүүлэх өөр шинэ дорвигийн арга хэмжээг эртнээс зохион байгуулж хэрэгжүүлэхгүй зөвхөн малынхаа тоо толгойн өсөлтөд найдаад суугаад байх юм бол Монгол улс 2010 оноос цааш стратегийн бүтээгдэхүүний хомсдолд ороход тун ойрхон болж магадгүй байна.

**Товч дүгнэлт**

1. Манайд бүтээгдэхүүнийг газар, малын эрчимжилтээр биш, бэлчээр нутаг, малын тоонд дулдуйдан үйлдвэрлэж байна. Иймэрхүү хөгжил муутай аж ахуйн хэвшилтэй орон дэлхийд 40-өөдхөн (217 орноос) үлджээ.
2. Бүрэн усжуулж ашигласан тохиолдолд Монгол нутагт биет бүтцээр 40 сая мал өсөж, үржих бэлчээрийн нөөц бий.
3. Монгол мал нэгжийн ашиг шимиин гарцаар эрчимжсэн МАА-тай өрсөлдөх боломжгүй. Тиймээс цаашид дэлхийн зах зээлд ашиг шимиин хэмжээгээр биш, харин байгалийн цэвэр бүтээгдэхүүнийхээ чанараар өрсөлдөх нь зүйтэй.
4. Бэлчээрийн МАА-г, байгалийн бэлэн бэлчээр, усыг ашиглаж үлэмж хямд зардлаар бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг учраас ихээхэн ашигтай аж ахуйн хэлбэр гэж үзэх явдал байдаг. Энүүнд зохих үндэслэл бий. Тэжээл тарьж бэлтгэх, гараар мал тэжээх (бас нэлээд нутагт услах) гэж хөдөлмөр зардаггүй. Тухайлбал, одоо байгаа малын, (2000 оны) бэлчээрээс идэж байгаа ёвс ногоог зөвхөн хадаж бэлтгэсэн ёвсний (хадлангийн) өргөөр үнэлвэл 700-800 тэрбум төгрөг болох бөгөөд энэ нь МАА-н нийт материаллаг зардлаас ойролцоогоор 9-10 дахин илүү юм. Үүгээрээ байран МАА-гаас давуутай бөгөөд энэ нь түүний зохих ашигтай байхын гол үндэс болдог.
5. Хэрвээ дэлхийн түвшинд хүргэж боловсруулан бэлэн бүтээгдэхүүн болгож чадвал МАА-д дэлхийн зах зээлд монополь байх хоёр төрлийн (ямааны ноолуур, тэмээний ноос), өрсөлдөх чадвартай мөн хоёр төрлийн бүтээгдэхүүн (хонь, үхэр, адууны мах, үхэр, хонь ямааны арьс, шир зэрэг) бий. Ингэсэн нөхцөлд ойрын 10-15 жилд хамгийн багаар бодоход жилд дунджаар ноолуураас (бэлэн бүтээгдэхүүнээр тооцоход) 250 сая, тэмээний ноосноос (бэлэн бүтээгдэхүүнээр) 45 сая, хонины ноосноос (угааснаар) 40-50 сая, арьс, ширнээс (анхны боловсруулалтаар) 50 сая, махнаас (анхны боловсруулалтаар) 60-70 сая, бүгд 450 сая гаруй ам.доллартай тэнцэх бүтээгдэхүүн экспортлох бололцоотой гэсэн тооцоо гардаг.